

# CR330E



**Ачих жин (даац):** 300 Тн  
**Өөрийн жин:** 216 Тн  
**Тэвшний эзэлхүүн:** 218 м<sup>3</sup>  
**Хөдөлгүүрийн чадал:** 3000 HP  
**Хөдөлгүүр:** Дизель (MTU16v4000C23)

**CRRC DATONG CO.,LTD.**

# CRRC

**“Биг Могол Экуйпмент” ХХК** нь БНХАУ-ын 1954 онд байгуулагдсан, галт тэрэгний зүтгүүр болон уул уурхайн хүнд даацын техник үйлдвэрлэгч CRRC Datong Co., Ltd компанийн Монгол Улс дахь албан ёсны түнш юм. CRRC Datong нь 71 жилийн туршлага, дэвшилтэт технологидоо тулгуурлан цахилгаан зүтгүүрийн технологийг шингээсэн, эрчим хүчний хэмнэлтэй, байгальд ээлтэй хүнд даацын техникүүдийг зах зээлд амжилттай нэвтрүүлж байна.

**CRRC DATONG CO., LTD** 1954 оноос уурын зүтгүүр үйлдвэрлэлээр үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд Герман улсын дэвшилтэт инженерчлэл, судалгаа, хөгжүүлэлтийн (R&D) инновацад суурилан галт тэрэгний ус төрөгчийн болон цахилгаан хөтлөгчийн технологи бүхий зүтгүүрийг үйлдвэрлэлдээ нэвтрүүлээд байна. Өнөөдөр CRRC Datong нь өөрийн арвин туршлага, дэвшилтэт технологид тулгуурлан ухаалаг, ногоон эрчим хүчинд суурилсан интеграцчилсан хяналтын систем, өндөр бүтээмж, бат бөх хийц бүхий байгальд ээлтэй уул уурхайн хүнд даацын автосамосвал үйлдвэрлэх шийдлүүдийг амжилттай нэвтрүүлж, салбартаа технологийн шинэчлэлийг тэргүүлэн ажиллаж буй олон улсын хэмжээний үйлдвэрлэгч компани юм.

## ХӨДӨЛГҮҮР

|                     |                                     |                    |
|---------------------|-------------------------------------|--------------------|
| Загвар: MTU 16V4000 | Хөдөлгүүр ажлын горим (такт): 4     | Цилиндрийн тоо: 16 |
| Эзэлхүүн: 76.3 л    | Морины хүч: 3000 НР                 |                    |
| Цэвэр жин: 8100 кг  | Мушгих хүч: 12,566 Нм @1700 эрг/мин |                    |

## ЦАХИЛГААН ХӨТЛӨГЧИЙН СИСТЕМ

|                                                 |                        |
|-------------------------------------------------|------------------------|
| Хувьсах гүйдлийн генератор: YJ177E2             | Удирдлага: tPower-TC30 |
| Редукторын бууруулах дамжуулгын тоо: 32.6 (±1%) | Хурд (дээд): 58 км/цаг |

## ЖОЛООЧИЙН БҮХЭЭГ

Цохилт болон уналтаас хамгаалах бүтэцтэй (ROPS/FOPS), аюулгүй байдлын хувьд ISO 3449-2005, ISO 3471-2008 стандартуудыг хангасан. Доргилт шингээх суудал, жолоочид ээлтэй дотоод засал, өргөн харах орчинтой цонх, тохируулгатай жолооны хүрд, халуун/хүйтнээр үлээгч агааржуулагч, шил арчигчтай. Давхар шалны хийц нь дуу чимээ тусгаарлалт, битүүмжлэлийг сайжруулсан.

## ЖОЛООДЛОГЫН СИСТЕМ

Тогтмол даралтын гидро-жолоодлоготой. Жолоодлогын гидро-аккумулятор нь ослын үед нөөц тэжээлээр хангаж, системийн аюулгүй, найдвартай байдлыг нэмэгдүүлнэ. Жолоодлогын систем нь ISO 5010 стандартын шаардлагыг хангасан.

- **Эргэлтийн хамгийн бага радиус: 15.5 м**

## ТЭВШ ӨРГӨХ СИСТЕМ

Цахилгаан удирдлагатай гидро насосоор тэжээгддэг өргөх систем нь хоёр талын үйлдэлтэй, гурван шатлалт өргөх цилиндрийг удирдаж, тэвшийг өргөх, буулгах, барих, хөвөх үйлдлүүдийг гүйцэтгэнэ.

1.Өргөх хугацаа: 24 сек

2.Буулгах хугацаа: 22 сек

## ТООРМОСНЫ СИСТЕМ

**Ажлын тоормос:** Гидравлик болон цахилгаан тоормос нь машиныг тоормослох хүчээр хангаж, явалтын аюулгүй байдлыг хангана. Урд болон хойд дугуй нь нийт 97019 см<sup>2</sup> үрэлтийн талбай бүхий дискен тоормостой.

**Урд дугуй:** Дискэн тоормос, үрэлтийн нийт талбай 97,019 см<sup>2</sup>.

**Хойд дугуй:** Дискэн тоормос, үрэлтийн нийт талбай 97,019 см<sup>2</sup>

**Удаашруулах тоормос:** Агаарын хөргөлттэй эсэргүүцлийн тор бүхий цахилгаан тоормосны систем нь үр ашигтай, аюулгүй, найдвартай удаашруулах хүчийг бий болгоно.

**Агшин зуурын тоормосны дээд чадал:**  
4030 кВт

**Тасралтгүй тоормосны дээд чадал:** 3030 кВт

## СТАНДАРТ ТОНОГЛОЛ

**Жолоочийн бүхээг:** ROPS ба FOPS хамгаалалт, дуу тусгаарлагчтай доторлогоо, агааржуулагч/халаагуур, доргилт багасгах суудал, тохируулгатай жолооны хүрд, радио гэх мэт.

**Удирдлагын эд анги:** Хурд баригч, тэвш өргөх товчлуур, зогсоолын тоормосны товчлуур, ослын тоормосны товчлуур, ослын зогсолтын товчлуур гэх мэт.

**Хянах самбар:** Хурд/эргэлтийн заалт, түлшний заалт, анхааруулах гэрэл/дуут дохио, шингэн LCD дэлгэц, гэмтлийн дохиолол гэх мэт.

**Ерөнхий:** Агаарын шүүлтүүр, дискэн тоормос, төвлөрсөн тосолгоо, автомат гал унтраагуур, хойд талыг харах толь, ослын тоормосны удирдлага гэх мэт.

## ДААЦЫН ХУВААРИЛАЛТ

### Ачаагүй үед:

Урд тэнхлэг: 108,000 кг (50%)

Хойд тэнхлэг: 108,000 кг (50%)

Нийт жин: 216,000 кг

### Ачаатай үед:

Урд тэнхлэг: 175,440 кг (34%)

Хойд тэнхлэг: 340,560 кг (66%)

Нийт жин: 516,000 кг

## ШИНГЭНИЙ БАГТААМЖ

Хөдөлгүүрийн тос: 300 л

Хөргөлтийн систем: 1050 л

Түлшний сав: 5000 л


Гидравлик тосны сав: 1500 л

Гидравлик тос хийх хэмжээ: 1200 л



Захын дамжуулагч (нэг тал): 90 л

# Оврын Хэмжээ

Хэмжээ: mm



## Гүйцэтгэлийн муруй



АЛБАН ЁСНЫ ДИСТРИБЮТЕР



Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
1-р хороо, Элчингийн гудамж- 9, Скай плаза, 201 тоот

УТАС +976 70706868

Web: www.bmeq.mn